ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2026/028/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Зуунмод 2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитор Г.Сугармаа
Утас: 70273465 Цахим хаяг: sugarmaag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........................................................................2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....................................4
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.........................................................................................12

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ТӨХК | Төрийн өмчит хувьцаат компани |
| УБЦТС | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

**ТӨВ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tov@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.02.25 № 01/113

танай ______________ -ны № ______________ -т

ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ У.ОДГЭРЭЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын онцолсон хэсэг**

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газар нь сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулах, оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилго тавьж ажиллажээ. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу бүртгэлгүй байсан 8,638,423.0 мянган төгрөгийн 8 газрыг үнэлүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэснээр нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3 дахин өсөхөд голлох нөлөөг үзүүлжээ.

**Аудитын гол асуудал**

Тайлант оны эхэнд авлага дансны үлдэгдэл 1,324,647.0 мянган төгрөг байснаас оны эцэст 110,361.2 мянган төгрөг болж буурсан байна. Энэ нь сумын ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны барилгын ажлыг тайлант онд хүлээн авч, холбогдох байгууллагын данс бүртгэлд шилжүүлсэнтэй холбоотой байна.

41?6020275

**Бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Баян сумын Засаг даргын Тамгын газар нь 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 35 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан баталснаас хэрэгжилт 86,0 хувьтай дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,394,549,636.4 | 203,519,116.6 |
| 33 | АВЛАГА | 1,324,647,011.8 | 110,361,201.0 |
| 335 | Бусад авлага | 1,324,647,011.8 | 110,361,201.0 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,324,647,011.8 | 110,361,201.0 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 69,902,624.6 | 93,157,915.6 |
| 351 | Түүхий эд материал | 3,525,901.8 | 3,281,231.8 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,860,261.8 | 1,860,261.8 |
| 35130 | Эм боох материал | 1,665,640.0 | 1,420,970.0 |
| 354 | Хангамжийн материал | 64,826,722.8 | 88,266,683.8 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,961,080.0 | 3,355,680.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 53,344,342.8 | 52,963,703.8 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,754,000.0 | 1,144,000.0 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 400,000.0 | 0.0 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,367,300.0 | 30,803,300.0 |
| 35600 | Мал амьтад | 1,550,000.0 | 1,610,000.0 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,343,799,271.5 | 12,836,277,720.6 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 4,343,799,271.5 | 12,836,277,720.6 |
| 392 | Биет хөрөнгө | 3,636,738,771.3 | 3,751,447,220.7 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,806,336,949.8 | 2,963,212,909.4 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,803,645,285.2 | -1,870,637,389.0 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 177,078,600.0 | 549,843,116.1 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -120,199,211.0 | -146,769,533.3 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 187,198,447.2 | 190,173,240.1 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -90,039,733.7 | -117,067,777.4 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 66,529,158.2 | 70,830,066.1 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -33,815,353.4 | -32,339,638.6 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 1,809,595,963.0 | 1,809,595,963.0 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | 0.0 | -139,199,689.4 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 1,103,850.0 | 1,103,850.0 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 919,039,563.1 | 817,429,719.1 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -282,444,176.8 | -344,727,615.5 |
| 393 | Биет бус хөрөнгө | 707,060,500.2 | 9,084,830,500.0 |
| 39301 | Программ хангамж | 10,342,500.0 | 10,342,500.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,739,999.8 | -4,742,500.0 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 699,458,000.0 | 9,079,230,500.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,738,348,907.9** | **13,039,796,837.2** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,391,057.0** | **283,834,000.0** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,391,057.0 | 283,834,000.0 |
| 413 | Өглөг | 1,391,057.0 | 283,834,000.0 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.0 | 2,197,200.0 |
| 4136 | Бусад өглөг | 1,391,057.0 | 281,636,800.0 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,391,057.0 | 281,636,800.0 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 5,736,957,850.9 | 12,755,962,837.2 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 5,736,957,850.9 | 12,755,962,837.2 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,262,355,725.4 | 1,262,355,725.4 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,262,355,725.4 | 1,262,355,725.4 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 3,513,879,948.6 | 10,532,884,934.9 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,513,879,948.6 | 2,419,493,400.6 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 8,113,391,534.3 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 960,722,177.0 | 960,722,177.0 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,738,348,907.9** | **13,039,796,837.2** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **6,938,185,396.6** | **10,292,324,052.0** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,910,192,421.9 | 8,655,131,616.1 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,910,192,421.9 | 8,655,131,616.1 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал | 0.0 | 14,988,600.0 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө | 0.0 | 8,640,143,016.1 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,027,992,974.6 | 1,637,192,435.8 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 789,729,874.6 | 204,763,735.8 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,000,000.0 | 0.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 83,141,444.5 | 78,859,399.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 514,741,425.0 | 10,798,624.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 188,847,005.1 | 115,105,712.8 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 4,238,263,100.0 | 1,432,428,700.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 4,238,263,100.0 | 1,432,428,700.0 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,282,565,161.3** | **1,674,184,517.3** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,616,420,653.6 | 1,670,384,517.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,110,970,789.1 | 1,291,336,576.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 550,901,618.9 | 664,872,979.1 |
| 210101 | Үндсэн цалин | 324,212,181.3 | 373,043,556.8 |
| 210102 | Нэмэгдэл | 214,036,157.7 | 275,560,310.7 |
| 210104 | Урамшуулал | 12,653,280.0 | 16,269,111.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 66,402,483.2 | 75,783,085.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,975,756.0 | 52,082,539.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,502,624.6 | 6,600,992.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,186,213.5 | 3,950,442.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,341,531.1 | 2,607,272.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,396,358.0 | 10,541,838.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 70,614,004.2 | 82,299,724.7 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,482,596.2 | 21,168,316.7 |
| 210302 | Түлш, халаалт | 61,131,408.0 | 61,131,408.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 43,263,349.0 | 39,265,539.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,627,710.0 | 3,627,600.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,573,910.0 | 19,152,400.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,100,450.0 | 993,400.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 8,955,280.0 | 7,963,550.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 158,700.0 | 564,090.0 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 5,847,299.0 | 6,964,499.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,821,600.0 | 8,125,490.0 |
| 210604 | Урсгал засвар | 1,821,600.0 | 8,125,490.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,838,000.0 | 7,650,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,838,000.0 | 7,650,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,843,565.0 | 9,020,690.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,141,490.0 | 4,200,000.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,612,800.0 | 1,936,800.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 273,825.0 | 213,840.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 370,900.0 | 515,365.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 143,000.0 | 165,000.0 |
| 210807 | Газрын төлбөр | 2,301,550.0 | 1,989,685.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 365,286,168.8 | 404,319,068.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 119,922,955.3 | 26,165,980.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 245,363,213.5 | 378,153,088.3 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,505,449,864.5 | 379,047,941.1 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0.0 | 231,715,794.7 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0.0 | 231,715,794.7 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 23,369,976.7 | 53,718,026.5 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 5,757,700.0 | 22,794,970.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.0 | 30,061,056.5 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 14,892,277.5 | 0.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,719,999.2 | 862,000.0 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,482,014,711.9 | 93,614,119.8 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,482,014,711.9 | 93,614,119.8 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 65,175.9 | 0.0 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 65,175.9 | 0.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 666,144,507.7 | 3,800,000.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 666,144,507.7 | 3,800,000.0 |
| 220001 | Барилга байгууламж | 601,071,864.0 | 0.0 |
| 221001 | Их засвар | 25,037,577.0 | 0.0 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 13,755,666.7 | 0.0 |
| 223001 | Бусад хөрөнгө | 26,279,400.0 | 3,800,000.0 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 2,655,620,235.3 | 8,618,139,534.6 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 304,717,177.2 | 504,748,000.3 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 7,177,829.2 | 497,768,400.3 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 297,539,348.0 | 6,979,600.0 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -304,717,177.2 | -504,748,000.3 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **2,350,903,058.1** | **8,113,391,534.3** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **5,044,892,274.6** | **1,637,192,435.8** |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,044,892,274.6 | 1,637,192,435.8 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 806,629,174.6 | 204,763,735.8 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,000,000.0 | 0.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 83,141,444.5 | 78,859,399.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 514,741,425.0 | 10,798,624.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 205,746,305.1 | 115,105,712.8 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 4,238,263,100.0 | 1,432,428,700.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 4,238,263,100.0 | 1,432,428,700.0 |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,309,104,753.8** | **1,302,559,777.0** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,309,104,753.8 | 1,302,559,777.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 803,774,889.3 | 923,271,836.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 550,901,618.9 | 664,872,979.1 |
| 210101 | Үндсэн цалин | 324,212,181.3 | 373,043,556.8 |
| 210102 | Нэмэгдэл | 214,036,157.7 | 275,560,310.7 |
| 210104 | Урамшуулал | 12,653,280.0 | 16,269,111.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 66,402,483.2 | 75,783,085.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,975,757.0 | 52,082,539.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,502,624.6 | 6,600,992.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,186,213.5 | 3,950,442.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,341,531.1 | 2,607,272.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,396,357.0 | 10,541,838.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 70,614,004.2 | 82,299,724.7 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,482,596.2 | 21,168,316.7 |
| 210302 | Түлш, халаалт | 61,131,408.0 | 61,131,408.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 39,551,010.0 | 30,670,350.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,986,900.0 | 4,101,200.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,287,380.0 | 17,012,200.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,146,450.0 | 993,400.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,015,280.0 | 7,441,550.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,115,000.0 | 1,122,000.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,746,540.0 | 11,790,550.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.0 | 5,799,600.0 |
| 210604 | Урсгал засвар | 7,746,540.0 | 5,990,950.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,838,000.0 | 7,544,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,838,000.0 | 7,544,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,452,508.0 | 8,474,947.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,141,490.0 | 4,200,000.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,224,000.0 | 388,800.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 273,825.0 | 213,840.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 370,900.0 | 515,365.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 143,000.0 | 165,000.0 |
| 210807 | Газрын төлбөр | 1,299,293.0 | 2,991,942.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 57,268,725.0 | 41,836,200.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 57,268,725.0 | 41,836,200.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,505,329,864.5 | 379,287,941.1 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0.0 | 231,715,794.7 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0.0 | 231,715,794.7 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 23,249,976.7 | 53,958,026.5 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,157,700.0 | 23,034,970.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.0 | 30,061,056.5 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 14,892,277.5 | 0.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,199,999.2 | 862,000.0 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,482,014,711.9 | 93,614,119.8 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,482,014,711.9 | 93,614,119.8 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 65,175.9 | 0.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 65,175.9 | 0.0 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 1,735,787,520.8 | 334,632,658.8 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 1,735,787,520.8 | 334,632,658.8 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,735,787,520.8 | 334,632,658.8 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,735,787,520.8 | 334,632,658.8 |
| 220001 | Барилга байгууламж | 549,131,864.0 | 0.0 |
| 221001 | Их засвар | 120,231,262.8 | 2,225,000.0 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 770,000.0 | 0.0 |
| 223001 | Бусад хөрөнгө | 79,315,466.0 | 0.0 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 986,338,928.0 | 332,407,658.8 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -1,735,787,520.8 | -334,632,658.8 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 0.0 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,262,355,725.35** | **960,722,176.97** | **3,513,879,948.60** | **5,736,957,850.92** |
| D01 | **2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,262,355,725.35** | **960,722,176.97** | **3,513,879,948.60** | **5,736,957,850.92** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | -1,094,386,548.00 | -1,094,386,548.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,262,355,725.35** | **960,722,176.97** | **2,419,493,400.60** | **4,642,571,302.92** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 8,113,391,534.29 | 8,113,391,534.29 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,262,355,725.35** | **960,722,176.97** | **10,532,884,934.89** | 12,755,962,837.21 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,537,471,000.00** | **1,200,712,905.30** | **3,336,758,094.70** | **26.46** |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 1,068,693,500.00 | 871,290,246.50 | 197,403,253.50 | 81.53 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,010,946,400.00 | 817,332,220.00 | 193,614,180.00 | 80.85 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 622,019,100.00 | 594,650,489.10 | 27,368,610.90 | 95.60 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Үндсэн цалин | 378,273,700.00 | 373,043,556.80 | 5,230,143.20 | 98.62 |
| Нэмэгдэл | 219,710,900.00 | 205,680,365.70 | 14,030,534.30 | 93.61 |
| Урамшуулал | 24,034,500.00 | 15,926,566.60 | 8,107,933.40 | 66.27 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 77,752,400.00 | 67,642,759.20 | 10,109,640.80 | 87.00 |
| Тэтгэврийн даатгал | 52,871,700.00 | 46,433,278.00 | 6,438,422.00 | 87.82 |
| Тэтгэмжийн даатгал | 6,220,200.00 | 5,902,259.00 | 317,941.00 | 94.89 |
| ҮОМШӨ-ний даатгал | 3,110,000.00 | 3,573,267.50 | -463,267.50 | 114.90 |
| Ажилгүйдлийн даатгал | 3,110,000.00 | 2,324,241.60 | 785,758.40 | 74.73 |
| Эрүүл мэндийн даатгал | 12,440,500.00 | 9,409,713.30 | 3,030,786.70 | 75.64 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 86,899,600.00 | 82,299,724.70 | 4,599,875.30 | 94.71 |
| Гэрэл, цахилгаан | 23,368,100.00 | 21,168,316.70 | 2,199,783.30 | 90.59 |
| Түлш, халаалт | 61,131,500.00 | 61,131,408.00 | 92.00 | 100.00 |
| Цэвэр, бохир ус | 2,400,000.00 | 0 | 2,400,000.00 | 0.00 |
| Хангамж, бараа материалын зардал | 41,702,200.00 | 29,382,650.00 | 12,319,550.00 | 70.46 |
| Бичиг хэрэг | 3,521,000.00 | 4,101,200.00 | -580,200.00 | 116.48 |
| Тээвэр, шатахуун | 21,320,000.00 | 15,814,500.00 | 5,505,500.00 | 74.18 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,200,000.00 | 903,400.00 | 3,296,600.00 | 21.51 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 11,250,000.00 | 7,441,550.00 | 3,808,450.00 | 66.15 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,411,200.00 | 1,122,000.00 | 289,200.00 | 79.51 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 43,000,000.00 | 5,990,950.00 | 37,009,050.00 | 13.93 |
| Урсгал засвар | 43,000,000.00 | 5,990,950.00 | 37,009,050.00 | 13.93 |
| Томилолт, зочны зардал | 9,500,000.00 | 7,544,000.00 | 1,956,000.00 | 79.41 |
| Дотоод албан томилолт | 9,500,000.00 | 7,544,000.00 | 1,956,000.00 | 79.41 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,113,100.00 | 4,274,947.00 | 2,838,153.00 | 60.10 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,325,600.00 | 388,800.00 | 1,936,800.00 | 16.72 |
| Даатгалын үйлчилгээ | 350,000.00 | 213,840.00 | 136,160.00 | 61.10 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 550,000.00 | 515,365.00 | 34,635.00 | 93.70 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 198,000.00 | 165,000.00 | 33,000.00 | 83.33 |
| Газрын төлбөр | 3,689,500.00 | 2,991,942.00 | 697,558.00 | 81.09 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 122,960,000.00 | 25,546,700.00 | 97,413,300.00 | 20.78 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 122,960,000.00 | 25,546,700.00 | 97,413,300.00 | 20.78 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 57,747,100.00 | 53,958,026.50 | 3,789,073.50 | 93.44 |
| Бусад урсгал шилжүүлэг | 57,747,100.00 | 53,958,026.50 | 3,789,073.50 | 93.44 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 23,178,000.00 | 23,034,970.00 | 143,030.00 | 99.38 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 33,069,100.00 | 30,061,056.50 | 3,008,043.50 | 90.90 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 862,000.00 | 638,000.00 | 57.47 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 3,468,777,500.00 | 329,422,658.80 | 3,139,354,841.20 | 9.50 |
| Дотоод эх үүсвэрээр | 3,468,777,500.00 | 329,422,658.80 | 3,139,354,841.20 | 9.50 |
| Барилга байгууламж | 2,443,493,300.00 | 15,000,000.00 | 2,428,493,300.00 | 0.61 |
| Их засвар | 971,658,900.00 | 314,422,658.80 | 657,236,241.20 | 32.36 |
| Бусад хөрөнгө | 53,625,300.00 | 0 | 53,625,300.00 | 0.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **4,537,471,000.00** | **1,200,712,905.30** | **3,336,758,094.70** | **26.46** |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 4,535,901,700.00 | 1,200,712,905.30 | 3,335,188,794.70 | 26.47 |
| Орон нутгийн төсвөөс | 4,535,901,700.00 | 1,200,712,905.30 | 3,335,188,794.70 | 26.47 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 1,569,300.00 | 0 | 1,569,300.00 | 0.00 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,569,300.00 | 0 | 1,569,300.00 | 0.00 |
| АЖИЛЛАГСАДЫН ТОО | 24 | 20 | 4.00 | 83.33 |
| Удирдах ажилтан | 6 | 6 | 0.00 | 100.00 |
| Гүйцэтгэх ажилтан | 10 | 8 | 2.00 | 80.00 |
| Үйлчлэх ажилтан | 2 | 2 | 0.00 | 100.00 |
| Гэрээт ажилтан | 6 | 4 | 2.00 | 66.67 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **699,080,079.58** | **111,149,616.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **128,136,903.58** | 111,149,616.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 113,244,626.08 | 111,149,616.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 55,054,497.44 | 70,222,490.00 |
| 210102 | Нэмэгдэл | 55,054,497.44 | 69,879,945.00 |
| 210104 | Урамшуулал | | 342,545.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,673,863.66 | 8,140,326.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,668,183.87 | 5,649,261.67 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 550,543.78 | 698,733.46 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 277,519.72 | 377,174.60 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 235,523.45 | 283,031.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 942,092.84 | 1,132,125.05 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,071,150.00 | 1,287,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,071,150.00 | 1,197,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 90,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 5,799,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 5,799,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 891,489.98 | 4,200,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 891,489.98 | 4,200,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 43,923,625.00 | 21,499,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 43,923,625.00 | 21,499,500.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **699,080,079.58** | **111,149,616.00** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 699,080,079.58 | 111,149,616.00 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 83,024,388.60 | 78,854,916.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 511,851,099.98 | 10,795,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 104,204,591.00 | 21,499,500.00 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 5.1. Залруулсан алдаа

Аудитаар нийт 8,812,255.9 мянган төгрөгийн 3 алдаа[1] илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг үндсэн хөрөнгө, бараа материалаар салгаж бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.7-д “нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “ангилал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Аудитын үйлчилгээний төлбөр 1,936.8 мянган төгрөгийг өр төлбөрийн дансанд тусгалгүй орхигдуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-д "бүх өр төлбөр" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгө худалдсаны гарзыг 148,207.8 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн. Үнэ төлбөргүй гарсан зардалд шилжүүлсэн бараа материалыг дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.7-д “нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### 5.2. Залруулаагүй алдаа

Аудитаар нийт 407,465.2 мянган төгрөгийн 7 зөрчил[2] илэрснээс 17,654.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 389,811.2 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс аймаг, сумын төсвийн хөрөнгөөр нийт 279,500.0 мянган төгрөгийн 2 автомашины худалдан авах ажиллагааг 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдөр зарлаж, 10 дугаар сарын 13-ны өдөр тус тус гэрээ байгуулан, өр төлбөр үүсгэсэн, мөн өмнөх оноос дамжсан 110,311.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 370,976.6 мянган төгрөгөөр их боловч шинж чанарын хувьд материаллаг бус тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

#### 5.2.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

#### 5.2.2 Албан шаардлага

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**<u>Илрүүлэлт 1:</u>** Иргэдийн спортын бүсийн наадам зохион байгуулж 2,106.0 мянган төгрөгийн медалийн зардал гаргасан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "...зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

**<u>Илрүүлэлт 2:</u>** Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхгүйгээр Засаг даргын нөөц хөрөнгөөс 19 удаа 15,548.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 4.1-т "Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "...зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

**<u>Илрүүлэлт 3:</u>** Шилэн дансанд байршуулбал зохих 5 мэдээллийг хугацаа хоцроож, 8 мэдээллийг мэдээлээгүй. Өмнөх аудитаар нь шилэн данстай холбоотой зөвлөмж авч, 100 хувь хэрэгжүүлсэн гэж тайлагнасан боловч зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "...зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

### 5.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**<u>Илрүүлэлт 1:</u>** Аймаг, сумын төсвийн хөрөнгөөр нийт 279,500.0 мянган төгрөгийн 2 автомашины худалдан авах ажиллагааг 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдөр зарлаж, 10 дугаар сарын 13-ны өдөр тус тус гэрээ байгуулан, өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т "Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах", 13.1.2-т "Энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион

байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох" гэснийг тус тус зөрчсөн байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>** Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөх, өр төлбөр үүсгэхгүй байх арга хэмжээ авахыг зөвлөж байна.

**<u>Илрүүлэлт 2:</u>** Өмнөх оноос дамжсан 110,311.2 мянган төгрөгийн авлага барагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн "Тохиолдсон байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>** Цаашид авлагыг барагдуулж, зөрчлийг давтан гаргахгүй байхыг зөвлөж байна.

**<u>Илрүүлэлт 3:</u>** Санхүүгийн тайлангийн программыг данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасныг зөрчсөн байна.

**<u>Шийдвэрлэсэн нь</u>:** Санхүүгийн тайлангийн программыг данс бүртгэлд тусгах арга хэмжээ авахыг зөвлөж байна.

**<u>Илрүүлэлт 4:</u>** Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 127 ш үндсэн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн байна. Цаашид ашиглах боломжтой хөрөнгөд дахин үнэлгээ хийж үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т "төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", 31 дүгээр зүйлийн 31.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх зарчим", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-тай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь</u>:** Холбогдох стандарт, журамд нийцүүлэн дахин үнэлгээ хийж, бүртгэлийг шинэчилж, зөрчлийг давтан гаргахгүй байхыг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөөг, зөвлөмжийн хэрэгжилтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг үндсэн хөрөнгө, бараа материалаар салгаж бүртгээгүй. | 1 | 8,655,131.6 | 1 | 8,655,131.6 | 1 | 8,655,131.6 | | |
| Аудитын төлбөр 1,936.8 мянган төгрөгийг өр төлбөрийн дансанд тусгалгүй орхигдуулсан байна. | 1 | 1,936.8 | 1 | 1,936.8 | 1 | 1,936.8 | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгө худалдсаны гарзыг дутуу бүртгэсэн. Үнэ төлбөргүй гарсан зардалд шилжүүлсэн бараа материалыг дутуу тайлагнасан байна. | 1 | 155,187.5 | 1 | 155,187.5 | 1 | 155,187.5 | | |
| Дүн | 3 | 8,812,255.8 | 3 | 8,812,255.8 | 3 | 8,812,255.8 | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Иргэдийн спортын бүсийн наадам зохион байгуулж 2,106.0 мянган төгрөгийн медалийн зардал гаргасан байна. | 1 | 2,106.0 | | | 1 | 2,106.0 | | | | |
| Аймаг, сумын төсвийн хөрөнгөөр нийт 279,500.0 мянган төгрөгийн 2 | 1 | 279,500.0 | | | | | 1 | 279,500.0 | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| автомашины худалдан авах ажиллагааг 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдөр зарлаж, 10 дугаар сарын 13-ны өдөр тус тус гэрээ байгуулан, өр төлбөр үүсгэсэн байна. | | | | | | | | | | |
| Өмнөх оноос дамжсан 110,311.2 мянган төгрөгийн авлага барагдаагүй байна. | 1 | 110,311.2 | | | | | 1 | 110,311.2 | | |
| Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхгүйгээр Засаг даргын нөөц хөрөнгөөс 19 удаа 15,548.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна. | 1 | 15,548.0 | | | 1 | 15,548.0 | | | | |
| Санхүүгийн тайлангийн программыг данс бүртгэлд тусгаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | |
| Баян сумын ЗДТГ-ын 2025 санхүүгийн тайланд аудит хийхэд 127 ш үндсэн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн байна. Гэвч цаашид ашиглах боломжтой хөрөнгөд дахин үнэлгээ хийж үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | |
| **Дүн** | **6** | **407,465.2** | | | **2** | **17,654.0** | **4** | **389,811.2** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд байршуулбал зохих 5 мэдээллийг хугацаа хоцроож, 8 мэдээллийг мэдээлээгүй. Өмнөх аудитаар нь шилэн данстай холбоотой зөвлөмж авч, 100 хувь хэрэгжүүлсэн гэж тайлагнасан боловч зөрчлийг давтан гаргасан байна. | 1 | - | | | 1 | - | | |
| Нийт дүн | 1 | - | | | 1 | - | | |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn